



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/298

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 14 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний “Эдийн засгийн бодлого - Өгөөжтэй эдийн засаг” дэд хөтөлбөрийн 3.1.5. “Улсын салбарын дотоод аудитын стандартыг аймаг орон нутагт нэвтрүүлэх” зорилтын хүрээнд “Улсын салбарын дотоод аудитыг Хөвсгөл аймагт хөгжүүлэх дунд хугацааны стратеги” төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дотоод аудитуудыг мэргэшүүлэх сургалтын зардлын дэмжлэгт 1,800,000 (Нэг сая найман зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 1,800,000 (Нэг сая найман зуун мянга) төгрөгийг “Эрх зүй нийгмийн хэв журам хөтөлбөр”-ийн “Засаг даргад хуулиар олгосон үүрэг, эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах, мөн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт хангах арга хэмжээний” зардлаас гаргаж, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Батбилгүүн)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар)-т үүрэг болгосугай.

ДАРГА  П.ЛХАГВАЖАВ